



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын
төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*

Аудитын код: YAG-SAГ/2015/03/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот

2015 оны 4 дүгээр сар



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
oyungerels@audit.gov.mn

Аудитор: Ш.Отгонбаяр
Утас: 261885
Цахим хаяг:
otgonbyar.sh@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хавсралт 5: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтуудыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2015/03/СТА-ТЕЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 4 дугаар сарын 5-наас 2015 оны 4 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын аудитор Ш. Отгонбаяр хэрэгжүүлэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланг 2015 оны 4 дугаар сарын 3-ны өдөр ХЭГ/680 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 32, 388, 2008 оны 352, дугаар тушаалыг баримтлан ажилласан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой дараах хууль эрхийн актуудыг мөрдөж байна. Үүнд:

- Засгийн газрын тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Засгийн газрын хуралдааны журам
- Засгийн газрын ХЭГ-ын дүрэм

- Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийн хянан шийдвэрлэх журам
- Төсвийн тухай хууль
- НББ-ийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын эрхэм зорилго нь мэргэшлийн өндөр түвшний, цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр Ерөнхий сайд, Танхимыг шуурхай хангах, Засгийн газрын тасралтгүй, хэвийн, үр ашигтай ажиллагааны зохистой орчин бүрдүүлэхэд оршино.

Хэрэг эрхлэх газар нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дараах зорилтыг тодорхойлжээ.Үүнд:

- Засгийн газрын бодлого, шийдвэрийг боловсруулах, хуралдаанд бэлтгэх болон яам, Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Ерөнхий сайд, Танхим, бүх шатны Хурал, Засаг даргыг орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, нутгийн удирдлагын чиглэлээр өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон зөвлөлгөө, дэмжлэгээр шуурхай хангах, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааны үр нөлөөтэй, хэвийн жигд ажиллагааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт, шалгалт, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үр дүнд өгөх үнэлгээний үр ашгийг дээшлүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах;
- Танхимын хуралдааны зохион байгуулалт, хүний нөөцийн болон захиргааны удирдлагын манлайллыг хангах, төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагчид санхүүгийн үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх;

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.7-д зааснаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдын төсөв, Шадар сайдын ажлын алба, болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагуудын төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох заавар журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 11-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ЗГХЭГ болон түүний харъяа байгууллагууд Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн журам, зааврын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг бэлтгэхэд хэрэглэх зарчим, горимыг мөрдөн ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл хөтлөх, боловсруулах, нэгтгэх үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолохын ХХК-ийн “ПЛАСТИК-3.0” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлыг тогтоох

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын хэмжээнд суурилан 2 хувиар тооцож 446.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Дотоод хяналтын талаар

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасныг үндэслэн ЗГХЭГ-ын даргын 2012 оны 129 дүгээр тушаалаар “Дотоод аудитын дүрэм”-ийг баталсан байна. Үүнд:

- Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга хэлбэрийг нэвтрүүлэхэд дотоод аудитын үйл ажиллагааг чиглүүлэх;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудад засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх, зөвлөн туслах;

Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ХЭГ-т санхүүгийн хяналт, шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх 2 байцаагч шилжин ирсэн байна.

Дээрх 2 ажилтныг Ерөнхий сайд, Шадар сайд, ЗГХЭГ-ын багцын байгууллагуудад дотоод хяналтын чиглэлээр шалгалт хийлгэх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, төсөв, хөрөнгө мөнгөний талаарх мэдээллээр удирдлагыг хангаж тухай бүр шийдвэр гаргуулан ажиллаж байна.

Дотоод аудитын алба нь 2015 оны төлөвлөгөөнд 8 байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийх, шалгалт хийсэн байгууллагуудад өгсөн зөвлөмжийн дагуу гүйцэтгэлийн хяналт хийхээр тусгагдсан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын баталсан удирдамжийн дагуу Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар болон Төр, засгийн үйлчилгээний автобааз, Байр ашиглалтын нэгдсэн захиргааны 2014 оны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, шалгалтын дүнг удирдлагад танилцуулах шатандаа байна. Дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

Санхүүжилтийн орлогын эх үүсвэр:			/сая төгрөгөөр/
Д/Д	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
1	Улсын төсвөөс	20,583.4	19,938.5
2	Сургалтын төрийн сангаас	500,0	471.0
3	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,844.7	1,667.8
4	Туслах үйл ажиллагааны орлого	562,0	606.8
	Нийт дүн	23,490.1	22,684.1

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц 2014 онд Улсын төсвөөс 20,583.4 сая төгрөг, санхүүжилт авахаас 19,938.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. 2,906.7 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэйгээс сургалтын төрийн сангаас 471.0 сая, үндсэн үйл ажиллагааны орлого 1,667.8 сая, туслах үйл ажиллагааны орлого 606.8 сая, нийт 2,745.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,1 хувиар орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

Засгийн газрын 2014 оны 149 тоот тогтоолоор Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа, Төр, засгийн үйлчилгээний Автобааз, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар төсвөөс санхүүжилт авахгүй, орлогоороо санхүүжих зарчимд шилжсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар бичиг хэргийн зардал 12.9 сая, гадаад зочны зардал 161.3 сая, төсвийн хувиарлагдаагүй зардал 50.8 сая, нэг удаагийн буцалтгүй тусламж 1.1 сая төгрөгөөр хэтэрснийг бүлэг хооронд шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн талаар

Тайлант онд нэмэгдсэн хөрөнгийг задаргааг харуулбал: Худалдан авсан хөрөнгө 486.4 сая, шилжүүлэн авсан хөрөнгө 7,123.0 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн хөрөнгө

62,377.5 сая, хандиваар 531.9 сая нийт 70,518.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Акталсан хөрөнгө 307.7 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 87.6 сая, бусад шилжүүлсэн 801.9 сая, нийт 1,197.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Бараа материалын талаар

Тайлант онд худалдаж авсан бараа материал 2,999.6 сая, хандиваар 2.7 сая, шилжүүлж авсан хөрөнгө 15.8 сая, шилжүүлж авсан /бүтцийн өөрчлөлтөөр/ 2.6 сая, бусад хөрөнгө 36.8 сая, нийт 3,057.5 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Худалдаж, зарцуулсан хөрөнгө 2,786.0 сая, шилжүүлсэн болон бүтцийн өөрчлөлтөөр 325.8 сая, нийт 3,111.8 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Батлагдсан төсвийн гүйцэтгэл, 5 сая төгрөгөөс дээш гүйлгээний талаарх мэдээлэл, хөрөнгө болон концессын зүйлийн зарлага, санхүүжилтийн мэдээ, Төсвийн ерөнхийлөн захирагчийн гүйцэтгэлийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт, хүрсэн дүнгийн талаарх мэдээллийг хуульд заасан хугацаанд олон нийтэд мэдээлэн ажиллаж байна. Бусад мэдээллийн хувьд гүйцэтгэл гарсан тохиолдолд тухай бүр олон нийтэд **shilin dans.gov.mn** цахим хаягаар мэдээлэн ажиллаж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бараа материал, систем хоорондын тооцоо, авлага, өр төлбөр, зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

Сар шинээр өндөр настан 90 ахмадад 7.9 сая төгрөгийн бэлэг өгсөн боловч, ахмадуудад олгосон нэрс болон хүлээн авсан гарын үсэггүй кассын тайлангийн баримтын бүрдэл дутуу байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д “Анхан шатны баримтын бүрдэл, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлэх талаар удирдлагад зөвлөмж өгөх;

Төсөвт тусгагдаагүй “Шинэчлэлийн цонх” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сэтгүүл хэвлүүлэхэд 39.2 сая төгрөг, орон нутагт тараахад 9.4 сая төгрөг нийт 48.6 сая төгрөгийг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” 6.4.2-т “төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна. Төсөвт тусгагдаагүй зардал гаргахгүй байх талаар удирдлагад зөвлөмж өгөх;

1. Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар авлагын оны эхний үлдэгдэл 1,784.2 сая төгрөг тайлант онд 1,658.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба 7.0 хувиар авлага буурсан байна.

2. Өглөгийн оны эхний үлдэгдэл 1,456.3 сая төгрөг байснаас жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 2,594.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй ба тооцоо нийлж баталгаажуулсан байна. Өглөг өмнөх оноос 1,138.1 сая төгрөгөөр буюу 78.1 хувиар өссөн байна.

Өглөг үүссэн шалтгаан нь Удирдлагын академийн сургалтын төлбөрийн болон оюутны байрны төлбөрийн орлого болох 1,294.2 сая, Автобаазын тээврийн хөлсний 960.4 сая төгрөгийн урьдчилж орсон орлого, автобаазын хөрөнгө оруулалт техник хяналтын барьцаа болох 181.7 сая, Амралт үйлчилгээний цогцолборын ХХОАТ, НДШ-ийн 12.3 сая, Хилийн боомтын нэгдсэн захиргаа 10.5 сая, ЗГ-ын автобаазын тээвэр шатахууны тооцоогоор 107.1 сая, бусад 27.9 сая, нэр данс зөрүүтэй 0.3 сая, нийт 2,594.4 сая төгрөгийн өглөг тайлант онд үүссэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д: “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 3.1-д “төсвийн санхүүжилтийг бууруулснаар өр, авлага үүсгэхгүйгээр зардал хэмнэх боломжийг” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй тул авлага, өр төлбөрийг барагдуулах талаар удирдлагад зөвлөмж өгөх;

ЗГХЭГ-ын харьяа төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн зөрчлийн талаар

Монгол Төрийн түүхийн музей

2014 оны санхүүгийн тайланд Санхүүч-Аудит ХХК аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт өгч, 6.2 сая төгрөгийн авлага шийдвэрлэх талаар албан шаардлага өгсөн байна.

Боомтын нэгдсэн захиргаа

Боомтын нэгдсэн захиргаа байгуулахтай холбогдуулан ТӨХ-ны 2014 оны 317, 409 дүгээр тогтоолоор Гаалийн ерөнхий газар, мэргэжлийн хяналтын газар болон Өмнөговь аймгийн Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгчийн ажлын албанаас балансаас балансад авсан нийт 61.9 сая төгрөгийн хөрөнгийг Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 401 дүгээр тогтоолын дагуу холбогдох газруудад нь албан ёсоор хүлээлгэн өгөөгүй байна.

МУ-ын Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоол гарч Боомтын нэгдсэн захиргааг 3 сарын 1-нээс байгуулаад тайлант жилд 8 сар ажилласан боловч Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 401 дүгээр тогтоолоор хөрөнгийг нь буцаан авахаар шийдвэр гарчээ. Гэвч энэхүү байгууллагын үйл ажиллагаа цаашид хэрхэх талаар эрх зүйн акт гараагүй байна.

Дорнод аймгийн Хавирга боомтын 4.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй Эрэлч нохойн байгууламж ой хээрийн гал түймрийн гамшгаас болж 2014 оны 10 дугаар сард шатсан байна. Энэ байдлыг газар дээр нь шалгаж Прокурорын дүгнэлт тогтоол гарсан боловч санхүүгийн тайланд хөрөнгийг бэлэн байгаагаар тусгасан нь **“Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх”** гэсэн зарчмыг зөрчсөн байна.

Боомтын нэгдсэн захиргааны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд УАГ-аас аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт өгч дээрх асуудлыг шийдвэрлэх талаар 3 зөвлөмж өгсөн байна.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Засгийн газрын Хэрэг газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үүссэн 1,658.8 сая төгрөгийн авлага, 2,594.4 сая төгрөгийн өглөгийг бууруулах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт болон харьяа байгууллагуудын өмч хөрөнгийн шилжилт хөдөлгөөний асуудлыг нягтлах шаардлагатай гэж үзэж байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 4,309.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 4,309.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн болно. Алдааг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулсан болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмж

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж 2 зөвлөмж өгсөн.

Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн гэж үзэж “Зөрчилгүй” дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1: Мөнгөн хөрөнгө

Асуудал 2: Авлага, өр төлбөр

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг илрүүлэх боломжгүй юм.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ш.Солонго, СХОҮХ-ийн дарга Ж.Бямбасүрэн, санхүүгийн тайлангийн нэгтгэл хариуцсан референт Д.Цэцэгмаа нар болон санхүүгийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

1.Сар шинээр өндөр настан 90 ахмадад 7.9 сая төгрөгийн бэлэг өгсөн боловч, ахмадуудад олгосон нэрс болон хүлээн авсан гарын үсэггүй кассын тайлангийн баримтын бүрдэл дутуу байна.

2.Төсөвт тусгагдаагүй “Шинэчлэлийн цонх” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сэтгүүл хэвлүүлэхэд 39.2 сая төгрөг, орон нутагт тараахад 9.4 сая төгрөг нийт 48.6 сая төгрөгийг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д “Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлэх,Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”,6.4.2-т “төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж, төсөвт тусгагдаагүй зардал гаргахгүй байх;

Эрсдэлүүд

Төсвийг, үр ашиггүй зарцуулах;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлд тусган танилцуулж, зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар авлагын оны эхний үлдэгдэл 1,784.2 сая төгрөг тайлант онд 1,658.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба 0.9 хувиар авлага буурсан байна.

Өглөгийн оны эхний үлдэгдэл 1,456.3 сая төгрөг ба жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 2,594.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй ба тооцоо нийлж баталгаажуулсан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өглөг өмнөх оноос 1,138.1 сая төгрөгөөр буюу 78.1 хувиар өглөг өссөн байна.

Өглөг үүссэн шалтгаан нь Удирдлагын академийн сургалтын төлбөрийн болон оюутны байрны төлбөрийн орлого болох 1,294.2 сая, Авто баазын тээврийн хөлсний 960.4 сая төгрөгийн урьдчилж орсон орлого, авто баазын хөрөнгө оруулалт техник хяналтын барьцаа болох 181.7 сая, Амралт үйлчилгээний цогцолборын ХХОАТ, НДШ-ийн 12.3 сая, Хилийн боомтын нэгдсэн захиргаа 10.5 сая, ЗГ-ын автобаазын тээвэр шатахууны тооцоогоор 107.1 сая, бусад 27.9 сая, нэр данс зөрүүтэй 0.3 сая, нийт 2,594.4 сая төгрөгийн өглөг тайлант онд үүссэн байна.

Эрсдэлүүд

Авлага, өр төлбөр найдваргүй болох эрсдэл, /Т, Э, Ү/

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д: “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг, мөн Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын “3.1-д “төсвийн санхүүжилтийг бууруулснаар өр, авлага үүсгэхгүйгээр зардал хэмнэх боломжийг” гэж заасныг хэрэгжүүлэх, авлага, өр төлбөрөө барагдуулах;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлд тусган танилцуулж, зөвшөөрсөн болно.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА С.БАЯРЦОГТ ТАНАА

2015.04.23 № 743
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Санхүүгийн аудитын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
НИЙТ ДҮН	-	-
МӨНГӨН ХӨРӨНГӨ	400,219,448.76	700,912,665.78
Кассанд байгаа бэлэн мөнгө	69,229,190.00	111,758,637.19
Төгрөг\ ЖМС	44,779,457.54	41,837,008.57
Гадаад валют	24,449,732.46	69,921,628.62
Банкинд байгаа бэлэн мөнгө	330,990,258.76	589,154,028.59
Төгрөг	330,990,258.76	589,154,028.59
Төсөвт байгууллагын харилцах	20,001,214.00	187,866,286.00
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	234,368,990.43	401,287,742.59
Нэмэлт санхүүжилтийн харилцах	76,620,054.33	
АВЛАГА	1,784,185,795.50	1,658,840,427.00
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,883,445.39	5,139,766.34
Төлбөртэй үйлчилгээний авлага	212,895,031.46	134,909,427.59
Бусад авлага	1,569,407,318.65	1,518,791,233.07
Байгууллагаас авах авлага	1,555,982,657.64	1,509,178,680.06
Бусад зардлын тооцооны авлага	1,555,982,657.64	1,509,178,680.06
Хувь хүмүүсээс авах авлага	13,424,661.01	9,612,553.01
УРЬДЧИЛГАА	99,858,128.00	99,858,128.00
Бусад урьдчилгаа	99,858,128.00	99,858,128.00
БАРАА МАТЕРИАЛ	2,060,552,570.87	2,006,266,828.96
Түүхий эд материал	552,349,158.34	501,574,372.32
Тусгай зориулалттай материал	3,094,990.00	3,009,990.00
Дуусаагүй үйлдвэрлэл	60,935,047.00	54,935,047.00
Бэлэн бүтээгдэхүүн	488,319,121.34	443,629,335.32
Хангамжийн материал	1,502,293,412.53	1,498,782,448.64
Бичиг хэргийн материал	46,386,422.36	60,779,365.25
Аж ахуйн материал	345,111,135.81	343,590,212.68
Сэлбэг хэрэгсэл	69,829,707.22	108,484,493.50
Түлш, шатах тослох материал	27,245,235.13	29,075,459.87
Барилгын засварын материал	65,733,969.00	60,321,123.00
Хүнсний материал	489,342,088.72	535,650,293.27
Бусад бараа материал	458,644,854.29	360,861,501.07
Мал амьтад	5,910,000.00	5,910,000.00
Бусад		-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,344,815,943.13	4,465,878,041.74
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	49,332,999,668.07	109,497,384,999.05
Биет хөрөнгө	49,248,983,644.33	109,410,481,088.91
Барилга, байгууламж, орон сууц	41,294,866,828.95	63,409,222,410.46
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	75,842,529,916.83	106,111,914,106.83
Барилга, байгууламж орон сууц – Хуримтлагдсан элэгдэл	(34,547,663,087.88)	(42,702,691,696.37)
Авто-тээврийн хэрэгсэл	3,861,911,643.46	4,572,781,368.41
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	7,692,640,836.00	9,114,823,212.25
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(3,830,729,192.54)	(4,542,041,843.84)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,937,209,226.54	2,081,988,610.65

Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	3,785,457,735.33	4,088,531,397.47
Машин тоног төхөөрөмж(компьютер) – Хуримтлагдсан элэгдэл	(1,848,248,508.79)	(2,006,542,786.82)
Тавилга, аж ахуйн эд хогшил	910,482,083.29	820,459,973.16
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	2,670,280,178.43	2,669,444,733.62
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(1,759,798,095.14)	(1,848,984,760.46)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	620,857,022.85	677,767,022.85
Бусад үндсэн хөрөнгө	623,656,839.24	601,492,488.38
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	864,253,753.43	860,326,561.54
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(385,824,938.37)	(411,739,497.34)
Номын фонд	145,228,024.18	152,905,424.18
Дуусаагүй барилга, байгууламж		37,246,769,215.00
Биет бус хөрөнгө	84,016,023.74	86,903,910.14
Програм хангамж	67,642,306.85	75,955,143.45
Програм хангамж - Анхны өртөг	184,045,943.33	204,343,458.82
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(116,403,636.48)	(128,388,315.37)
Бусад биет бус хөрөнгө	16,373,716.89	10,948,766.69
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	38,665,747.49	38,665,747.49
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(22,292,030.60)	(27,716,980.80)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	53,677,815,611.20	113,963,263,040.79
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,456,292,716.03	2,594,396,685.94
Өглөг	112,189,221.55	348,433,390.49
Ажилчидтай холбогдсон тооцоо	2,305,168.00	18,853,111.95
НДШ-ийн өглөг		10,532,625.75
ХАОАТ-ын өглөг	2,305,168.00	8,320,486.20
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	11,494,036.24	107,110,029.93
Тээвэр шатахуунын тооцоо	1,801,610.03	107,110,029.93
Бусад зардлын тооцоо	9,692,426.21	
Бусад өглөг	98,390,017.31	222,470,248.61
Байгууллагад төлөх өглөг	98,390,017.31	222,081,998.01
Хувь хүмүүст төлөх өглөг		388,250.00
Урьдчилж орсон орлого	1,344,103,494.48	2,245,963,295.45
